



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Заавар, маягт батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Групп аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар"-ыг 1 дүгээр, "Нэгтгэлд оролцогч талуудыг тодорхойлох удирдамж"-ыг 2 дугаар, "Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд ашиглагдах үлгэрчилсэн маягтууд, тэдгээрийг нөхөх заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Тус зааврыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн групп аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 99 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

000374



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ЗААВАР

Нэгдүгээр бүлэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Энэхүү зааврын зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг хангасан толгой компани нь өөрийн охин компаниудын тус тусдаа бэлтгэсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэх, хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа тохируулж нэгтгэх замаар нэгтгэсэн санхүүгийн бэлтгэх удирдамжаар хангана.
2. Энэ зааврын 1.1-д заасан эцсийн толгой компани нь Компанийн тухай хуулийн 6.4-д заасны дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэнэ.
3. Өөрөө нэг ба түүнээс дээш охин компанитай, эдгээр охин компаниуд нь нэг ба түүнээс дээш охин компанитай гэх мэтээр үргэлжилсэн зохион байгуулалттай компанийн хамгийн сүүлчийн толгой компанийг **эцсийн толгой компани**, дээрээ толгой компанитай боловч өөрөөсөө салбарласан охин компанитай компанийг **завсрын толгой компани** гэнэ. Эцсийн толгой компани нь гадаад улсад байрладаг бол Монгол улсад бүртгэгдсэн хамгийн сүүлчийн толгой компанийг эцсийн толгой компани гэж үзнэ.
4. Дараах гурван нөхцөлийг хангасан толгой компани нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхгүй:
 - (а) Дараах бүх нөхцөлийг зэрэг хангаж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.3-д заасан Монгол улсад бүртгэлтэй охин компаниудын доторх дээд шатны толгой компаниас бусад толгой компани:
 - Өөр аж ахуйн нэгжийн охин компани болох завсрын толгой компанийн саналын эрхтэй ба эрхгүй бүх хувь эзэмшигчид нь нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахгүй болох тухайгаа мэдэгдсэн бол;
 - Тухайн толгой компани нь өөрийн гаргасан өрийн болон өмчийн санхүүгийн хэрэгслээ нээлттэй зах зээл (дотоод ба гадаадын хөрөнгийн бирж¹ эсвэл биржийн бус зах зээл², үүнд орон нутгийн ба бүс нутгийн зах зээл орно)-д арилжаалдаггүй бол;

¹ Үүнийг *Компанийн тухай* хуулийн 3.7 – д заасныг ойлгоно.

² Үүнийг *Компанийн тухай* хуулийн 3.8 – д заасныг ойлгоно.

- Тухайн толгой компани нь нээлттэй зах зээлд санхүүгийн аливаа хэрэглүүрийг гаргах зорилгоор үнэт цаасны хороо эсвэл бусад зохицуулагч байгууллагад санхүүгийн тайлангаа бүрдүүлж өгөөгүй эсвэл бүрдүүлж өгөх үйл явцыг эхлүүлээгүй бол;
- Тухайн толгой компанийн эцсийн эсвэл завсрын толгой компани нь СТОУС-д нийцсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг бол;

(б) НББОУС 19 “*Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж*”-ийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө

эсвэл бусад урт хугацаатай ажиллагсдын тэтгэврийн төлөвлөгөөтэй;

(в) Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь түүний хөрөнгө оруулсан үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг үзүүлдэгээс өөр охин компанитай бол, тэдгээрт оруулсан хөрөнгө оруулалтаа СТОУС 9-ийн дагуу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр нь хэмжих учраас нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхгүй.

5. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго, зорилт

5.1 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь нэгтгэлийн суурь зарчим болох хяналтыг үнэлэх (*Хавсралт 2 “Нэгтгэлд оролцогч талуудыг тодорхойлох удирдамж”*-г тус тус ашиглана.) замаар хяналтад тулгуурлан группын хувьд хөрөнгө, нөөц, хүлээсэн үүрэг, үйл ажиллагааны үр дүнг эдийн засгийн нэг нэгж байдлаар нэгтгэх, мөн хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар нэгтгэж тайлагнахад оршино.

5.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэр гаргахад нь шаардагдах группын хэмжээний Нэгтгэсэн санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч), Нэгтгэсэн санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), Нэгтгэсэн санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээ)-ийн талаарх мэдээллээр хангана.

5.3 Нэгтгэсэн санхүүгийн тайланг хууль эсвэл холбогдох дүрэм, журамд заасан хугацаанд үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг толгой компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ.

6. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх ерөнхий шаардлагууд

6.1 Толгой компани нь охин компанид хяналтаа тогтоосон өдрөөс хяналтаа алдах өдөр хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.

- 6.2 Толгой компанийн гаргасан нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд (хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал)-ийг хяналтаа тогтоосон охин компани тус бүрийн гаргасан нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангуудын эдгээр үзүүлэлтүүдтэй мөр мөрөөр нэгтгэнэ. Хэрвээ толгой компани бизнесийн нэгдлийн үр дүнд охин компанид хяналтаа тогтоосон бол худалдан авалтын аргаар нэгтгэнэ. Харин хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар тус тус тохируулах замаар нэгтгэж нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.
- 6.3 Нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн толилуулга ба ангилалд баримтлах зарчмыг нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд мөн адил хэрэглэх бөгөөд нэг тайлант үеэс дараагийн тайлант үед тогтвортой мөрдөнө.
- 6.4 Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулгад багтсан мэдээлэл нь зэрэгцүүлэгдэхүйц байвал зохино.
- 6.5 Энэ заавар болон нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх холбогдох СТОУС-аар цэвэр дүнг гаргахыг шаардсан эсвэл тусгайлан зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд группын хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй.

Хоёрдугаар бүлэг. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ

1. Аж ахуйн нэгжийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангуудыг нэгтгэлд бэлдэх

Групп доторх аж ахуйн нэгж тус бүр компани хоорондын болон холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ, үлдэгдлээ гаргахад зориулан дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, компани хоорондын бүхий л ажил гүйлгээг нэгтгэгдэх компани болон ажил гүйлгээний төрөл тус бүрээр бүртгэвэл зохино.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд залруулга хийх болон тодруулах дараах ажил гүйлгээ, үлдэгдлийг гаргах зорилгоор дэлгэрэнгүй бүртгэлийн загвар, маягт, ажил гүйлгээний агуулгыг группын хэмжээнд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогодоо тусгасан байна:

1.1 Компани хооронд хийгдсэн бүх ажил гүйлгээг өссөн дүнгээр гаргах

(борлуулалт, худалдан авалт, зээлдүүлэх ба зээлэх, ногдол ашиг төлөх болон хүлээн авах гэх мэт ажил гүйлгээний төрлөөр)

1.2 Компани хоорондын балансын дансыг үлдэгдлийн дүнгээр гаргах

(компани хоорондын авлага, өглөг, зээл, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, охин компанийн эздийн өмч гэх мэт тодорхой дансдын үлдэгдлээр)

1.3 Холбоотой талуудтай хийгдсэн бүх ажил гүйлгээг өссөн дүнгээр гаргах

(борлуулалт, худалдан авалт, зээлдүүлэх ба зээлэх, ногдол ашиг төлөх болон хүлээн авах гэх мэт ажил гүйлгээний төрлөөр)

1.4 Холбоотой талуудын балансын дансдыг үлдэгдлийн дүнгээр гаргах

(холбоотой талуудын авлага, өглөг, зээл гэх мэт тодорхой дансдын үлдэгдлийн дүнгээр)

Нэгтгэсэн санхүүгийн тайланд компани хоорондын ажил гүйлгээ, үлдэгдлийн нөлөөг бүрэн устгах буюу залруулга хийнэ. Харин холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ, үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулна.

2 Групп доторх аж ахуйн нэгжүүдийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангуудыг нэгтгэх

Нэгтгэлийг дараах үе шатаар хийнэ:

(а) Мөр мөрөөр нэгтгэх: /Групп доторх бүх аж ахуйн нэгжүүдийн (толгой болон охин компаниудын хамт) гаргасан нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангуудыг нэгтгэж, эдийн засгийн нэг нэгж мэтээр толилуулахын тулд толгой компанийн хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын зүйлсийг охин компанийн эдгээр зүйлстэй мөр мөрийн дагуу нэмэх байдлаар нэгтгэнэ./

(б) Тохируулах (устгах бичилт хийх): /Групп доторх аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж байгаа бүх ажил гүйлгээг уг группын аж ахуйн нэгж тус бүр **“Компани хоорондын ...”** гэсэн тодотголтой дансдыг ашиглан нягтлан бодох бүртгэлдээ тусгах ба групп доторх аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдсэн бүх ажил гүйлгээтэй холбоотой группын дотоод дахь хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого зардал болон мөнгөн гүйлгээг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгаж цэвэрлэнэ./

(в) Нэгтгэсэн үр дүнг гаргах: /Группын хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын зүйлсийг тохируулсны дараах нэгтгэсэн үр дүнг гаргаж, тайлагнана./

Групп доторх аж ахуйн нэгжүүдийн хооронд гарсан ажил гүйлгээнүүд нь янз бүрийн хэлбэртэй байдаг бөгөөд дараах байдлаар ангилж болно. Үүнд:

(а) Доош чиглэсэн /Толгой компаниас охин компани руу чиглэсэн ажил гүйлгээ/

(б) Дээш чиглэсэн /Охин компаниас толгой компани руу чиглэсэн ажил гүйлгээ/

(в) Хэвтээ чиглэсэн /Охин компани хоорондын ажил гүйлгээ/

Ажил гүйлгээний чиглэл ямар байхаас үл хамааран групп доторх ажил гүйлгээний нөлөөг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж цэвэрлэнэ.

2.1 Групп доторх аж ахуйн нэгжүүд хооронд хийгдсэн ажил гүйлгээ, үлдэгдлийг устгах

2.1.1 Групп доторх аж ахуйн нэгжүүд хооронд хийгдсэн ажил гүйлгээг устгах

2.1.1.1 Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд:

Групп доторх аль нэг аж ахуйн нэгжийн хувьд “**орлого**” хэмээн хүлээн зөвшөөрсөн дүнг групп доторх нөгөө аж ахуйн нэгж нь “**өртөг эсвэл зардал, хөрөнгө**” байдлаар хүлээн зөвшөөрсөн байж болно. Ийм тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланд хийх устгах бичилт дараах байдалтай байна:

(а) Компани хоорондын орлого – Компани хоорондын зардал

(Үйл ажиллагааны зардал, Борлуулалтын өртөг г.м)

	Дансны нэр	Тайлбар
Дт	Компани хоорондын орлого	Орлого болон зардлыг нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зүйл тус бүрээр устгана.
Кт	Компани хоорондын үйл ажиллагааны зардал	Жишээлбэл, Орлогын хувьд борлуулалтын орлого, түрээсийн орлого, хүүгийн орлого гэх мэтээр, үйл ажиллагааны зардлын
Кт	Компани хоорондын борлуулалтын өртөг	хувьд цалингийн зардал, элэгдлийн зардал, хүүгийн зардал гэх мэтээр

(б) Компани хоорондын орлого – Хуримтлагдсан ашиг (Ногдол ашиг зарлах)

	Дансны нэр	Тайлбар
Дт	Компани хоорондын орлого (Ногдол ашгийн)	Нэг талаас ногдол ашиг зарлах, нөгөө талаас ногдол ашгийн орлогыг нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд хүлээн
Кт	Хуримтлагдсан ашиг	зөвшөөрсөн дүнгээр

(в) Компани хоорондын орлого – Хөрөнгө (Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө борлуулах)

Эргэлтийн хөрөнгөд:

- Бараа материал

Эргэлтийн бус хөрөнгөд:

- Үндсэн хөрөнгө

- Бусад эргэлтийн хөрөнгө
- Биет бус хөрөнгө
- Хөрөнгө оруулалт
- Бусад эргэлтийн бус хөрөнгө

Хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн дүнд компани хоорондын бодит бус ашиг³ шингэсэн байж болно. Жишээлбэл, компани хоорондын бодит бус ашиг нь бараа материалын хувьд бол нийт ашиг, үндсэн хөрөнгийн хувьд үндсэн хөрөнгө борлуулсны олз хэлбэртэй байж болно. Компани хоорондын бодит бус ашгийг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгахдаа:

Эргэлтийн хөрөнгө

Компани хоорондын бараа материалын борлуулалтын ажил гүйлгээний үед компани хоорондын худалдан авагч тал нь тухайн бараа материалыг группээс гадуурх аж ахуйн нэгжид борлуулсан үед компани хоорондын бодит бус ашиг нь бодит ашиг болж хэрэгжинэ. Тухайн бараа материалаас тайлангийн хугацааны эцэст борлогдоогүй бараа материал үлдвэл бараа материалын үлдэгдэл нь тухайн үлдэгдэлд ногдох хэмжээний тайлант үеийн бодит бус ашгийг агуулж байгаа гэсэн үг. Тэгэхээр компани хоорондын бараа материалын ажил гүйлгээнээс бий болсон бодит болон бодит бус ашгийн дүнгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар устгах бичилт хийнэ:

Эхний үлдэгдлийн хувьд:

Дансны нэр	Тайлбар
Дт Хуримтлагдсан ашиг	Өмнөх тайлант үеийн эцсийн үлдэгдэлд ногдох бодит бус ашгийн дүнгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлээ тохируулахгүй бол нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь буруу илэрхийлэгдэхэд хүрнэ.
Дт Хойшлогдсон татварын хөрөнгө	
Кт Бараа материал	
Кт Татварын зардал	

Тайлант үед гарсан ажил гүйлгээний хувьд:

Дансны нэр	Тайлбар
Дт Компани хоорондын орлого	Бараа материалыг борлуулагч тал нь компани хоорондын борлуулалтын орлого болон борлуулалтын өртгийг тэнцүү
Кт Компани хоорондын борлуулалтын өртөг	дүнгээр хүлээн зөвшөөрсөн бол компани хоорондын ашиг, алдагдал агуулаагүй ажил гүйлгээ болно. Харин эдгээр дүнгүүд

³ Компани хоорондын бодит бус ашиг гэдэг нь групп доторх аж ахуйн нэгжүүд нь тухайн ажил гүйлгээний үр дүнг ялгаатай дүнгээр бүртгэх үед бий болно.

Кт Борлуулалтын өртөг зөрүүтэй бол ашиг, алдагдал агуулсан ажил гүйлгээ болох буюу зөрүү дүн нь бодит бус ашгийг илэрхийлнэ.

Компани хоорондын бараа материалыг худалдан авагч тал нь тухайн бараа материалыг группээс гадуурх аж ахуйн нэгжид борлуулсан бол борлуулсан дүнд ногдох бодит ашгийн дүнгээр Кт Борлуулалтын өртөг дансанд, борлогдоогүй бараанд ногдох бодит бус ашгийн дүнгээр Кт Бараа материал дансанд бичилт хийнэ.

Дээрх ажил гүйлгээтэй холбоотой бодит бус ашигт ногдох татварыг нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар тохируулна:

Дт	Хойшлогдсон хөрөнгө	татварын	Бараа материалын эцсийн үлдэгдэлд ногдох бодит бус ашигтай холбоотой үүсэх хойшлогдсон татвар.
Кт	Татварын зардал		

Эргэлтийн бус хөрөнгө

Эхний үлдэгдлийн хувьд:

	Дансны нэр	Тайлбар
Дт	Хуримтлагдсан ашиг	Өмнөх тайлант үед үүссэн аливаа хэрэгжээгүй олз (гарз) нь бүрэн хэрэгжээгүй бол, энэ үлдэгдэлд ногдох дүнгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлээ ийнхүү тохируулах шаардлагатай.
Дт	Хуримтлагдсан элэгдэл	
Дт	Хойшлогдсон хөрөнгө	
Кт	Үндсэн хөрөнгө	

Тайлант үед гарсан ажил гүйлгээний хувьд:

	Дансны нэр	Тайлбар
Дт (Кт)	Үндсэн хөрөнгө	Компани хоорондын үндсэн хөрөнгө борлуулалтын ажил гүйлгээгээр борлуулагч талын бүртгэлд үндсэн хөрөнгө борлуулахтай холбоотой аливаа олз (гарз) тусгагдсан бол энэ нь хэрэгжээгүй олз (гарз)-г илэрхийлэх тул тухайн хөрөнгийн элэгдлийн зардлыг залруулах замаар хэрэгжээгүй олз (гарз)-г тохируулна.
Дт (Кт)	Хуримтлагдсан элэгдэл	
Дт (Кт)	Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)	
Кт	Элэгдлийн зардал	

Дээрх ажил гүйлгээтэй холбоотой хэрэгжээгүй ашигт ногдох татварыг Нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар тохируулна:

Дт	Хойшлогдсон татварын	
(Кт)	хөрөнгө	Тайлант үеийн эцсийн байдлаарх хэрэгжээгүй олз (гарз)-д
Дт		ногдох хойшлогдсон татвар.
(Кт)	Татварын зардал	

2.1.1.2 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд:

Групп доторх аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдсэн аливаа мөнгөн урсгалтай холбоотой бүх ажил гүйлгээг өссөн дүнгээр Нэгтгэсэн санхүүгийн тайланд устгах бичилтийг дараах байдлаар тохируулж хийнэ. Үүнд:

	Дансны нэр	Тайлбар
Дт	Компани хоорондын төлсөн мөнгөн хөрөнгө	Устгах бичилтийг ажил гүйлгээний төрлөөр тохирох мөнгөн гүйлгээний ангиллын дагуу устгаж, тохируулна.
Кт	Компани хоорондын хүлээн авсан мөнгөн хөрөнгө	Жишээлбэл, компани хоорондын зээл төлбөр төлөх, бэлнээр хөрөнгө борлуулах гэх мэт.

2.1.2 Групп доторх аж ахуйн нэгжүүдийн хоорондын тооцооны үлдэгдлийг устгах

2.1.2.1 Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайланд:

Эхний үлдэгдлийн хувьд:

	Дансны нэр	Тайлбар
Дт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хувь нийлүүлсэн хөрөнгө гэдэгт охин компани тус бүрийн өмнөх тайлант үеийн эцсийн үлдэгдлээрх нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд тусгагдсан хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал, бусад
Кт	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	дэлгэрэнгүй орлого (үзүүлэлт тус бүрээр), хуримтлагдсан ашиг зэрэг багтана.
Кт	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь толгой компанийн өмнөх тайлант үеийн эцсийн үлдэгдлээрх нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд тусгагдсан дүн байна.
		Хяналтын эрхгүй хувь оролцоог охин компани тус бүрийн

өмнөх тайлант үеийн эцсийн үлдэгдлээрх нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгөөс охин компани тус бүрийн хяналтын эрхгүй хувь хэмжээг эзэмшигчдийн эзэмшлийн хувиар үржүүлсэн дүн байна.

Тайлант үеийн өөрчлөлтийн хувьд:

Дансны нэр	Тайлбар
Дт Ашиг (алдагдал)-с цөөнхөд ногдох (Кт) хувь	Охин компани тус бүрийн тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн тус бүрийн өөрчлөлтөөс хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдийн эзэмшлийн хувиар тохируулж, устгана.
Дт Нөөц (Бусад дэлгэрэнгүй орлогын (Кт) үзүүлэлт тус бүрээр)	
Дт Хяналтын эрхгүй хувь оролцоо (Кт)	

Тайлбар: Толгой компани нь хяналтын эрхгүй хувь оролцоогоо нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өмчийн хэсэгт толгой компанийн эзэмшигчдийн өмчөөс тусад нь толилуулах ёстой.

Дансны нэр	Тайлбар
Дт Компани хоорондын өр төлбөр	Групп доторх аж ахуйн нэгж тус бүрийн тусдаа бэлтгэсэн “Хоорондын тооцооны дэлгэрэнгүй бүртгэл”, “Хоорондын тооцооны товчоо” тайланд тусгагдсан үлдэгдлийн дүнгээр
Дт Компани хоорондын зээл	
Кт Компани хоорондын авлага	

2.2 Дахин ангилал хийх

Групп доторх аж ахуйн нэгжүүдийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд ангилж, хүлээн зөвшөөрсөн зарим дансдуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд группыг нэг эдийн засгийн нэгж мэтээр толилуулахтай холбоотойгоор дахин ангилал хийдэг.

2.2.1 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (ХОЗҮХХ) – Үндсэн хөрөнгө

Групп доторх аль нэг аж ахуйн нэгж нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд “Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө”-өөр ангилахдаа группын бусад нэгжээс хамааралтай(групп дотроо түрээсэлж орлого олох г.м)-гаар хүлээн зөвшөөрсөн (хүлээн зөвшөөрөх шалгуур нь группын бусад нэгжээс хамаарч хангагдсан) бол эдийн засгийн нэг нэгж мэтээр толилуулж байгаа группын нэгтгэсэн санхүүгийн тайланд “Үндсэн хөрөнгө”-өөр дахин

ангилна. Тиймээс нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар дахин ангиллын устгах бичилт хийнэ:

(а) ХОЗҮХХ-г өртгийн загвараар бүртгэж байсан бол:

	Дансны нэр	Тайлбар
Дт	Үндсэн хөрөнгө Хуримтлагдсан элэгдэл-Хөрөнгө	Өртгөөр нь
Дт	оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Хуримтлагдсан элэгдлийн дүнгээр
Кт	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Өртгөөр нь
Кт	Хуримтлагдсан элэгдэл-Үндсэн хөрөнгө	Хуримтлагдсан элэгдлийн дүнгээр
Дт (Кт)	Үндсэн хөрөнгө руу ангилсны олз (гарз)	Дахин ангилах үед ангилал хоорондын дансны үнэ зөрүүтэй байсан бол зөрүү дүнгээр

(б) ХОЗҮХХ-г бодит үнэ цэнийн загвараар бүртгэж байсан бол:

	Дансны нэр	Тайлбар
Дт	Үндсэн хөрөнгө Хуримтлагдсан элэгдэл-Хөрөнгө	Өртгөөр нь
Дт	оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Хуримтлагдсан элэгдлийн дүнгээр
Кт	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Бодит үнэ цэнээр нь
Дт (Кт)	Бодит үнэ цэнийнн зөрүүгийн олз (гарз)	Бодит үнэ цэнийн үнэлгээний тохируулгын дүнгээр
Дт (Кт)	Үндсэн хөрөнгө руу ангилсны олз (гарз)	Дахин ангилах үед ангилал хоорондын дансны үнэ зөрүүтэй байсан бол зөрүү дүнгээр

Жич: Группын бодлогоос өөр бодлогын хэрэглээг группын бодлого руу шилжүүлэх

Хөрөнгө түрээслэх үйл ажиллагааг тухайн групп доторх аж ахуйн нэгжүүддээ үзүүлдэг групп доторх аж ахуйн нэгж нь Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн загварыг хэрэглэдэг бол толгой компани буюу нэгтгэсэн санхүүгийн тайланбэлтгэх

тайлагнагч аж ахуйн нэгж нь эдгээр бодит үнэ цэнийн загварын хэрэглээтэй холбоотой охин компанийн бичилтүүдийг буцааж, өртгийн загвараар холбогдох тохируулгыг хийж нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэнэ. Ингэж тохируулах практик боломжгүй бол группын хэмжээний нийт үл хөдлөх хөрөнгийн бүлгийг бүхэлд нь дахин үнэлгээний загвараар хэмжинэ.

3 Хараат болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа нэгтгэх

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэн гаргаж байгаа толгой компани нь, хэрвээ хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалттай бол тэдгээрт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргын дагуу тохируулж, нэгтгэнэ. Өмчийн аргын дагуу дараах тохируулгуудыг хийнэ. Үүнд:

(а) Эхний үлдэгдлийн хувьд:

Дт (Кт) Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт

Дт (Кт) Хуримтлагдсан ашиг

Дт (Кт) Нөөц (Бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрээр)

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт Хойшлогдсон татварын өр төлбөр

Дт (Кт) Татварын зардал

(б) Тайлант үеийн хөрвүүлэлтийн хувьд:

Дт (Кт) Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт

Дт (Кт) Хөрвүүлэлтийн нөөц

(в) Тайлант үеийн өөрчлөлтийн хувьд:

Дт (Кт) Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт

Дт (Кт) Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтын ашиг, алдагдал

Дт (Кт) Нөөц (Бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрээр)

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт Хойшлогдсон татварын өр төлбөр

Дт (Кт) Татварын зардал

Дээрх устгах бичилтийн хөрөнгө оруулагчийн талын бүртгэлд хамаарах журналын бичилтийг дэлгэрэнгүйгээр харуулбал дараах байдалтай байна:

3.1 Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн ашиг, алдагдлын нөлөө

Дансны нэр

Тайлбар

Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлагнасан тайлант үеийн цэвэр ашиг

(алдагдал)-р:

Дт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн цэвэр ашиг
Кт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтын ашиг, алдагдал	(алдагдал)*хөрөнгө оруулагчийн хувь эзэмшил%

Хэрвээ тухайн тайлант үед хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр нь алдагдалтай ажилласан бол дээрх дансны харьцааны эсрэг журналын бичилт хийнэ.

3.2 Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн ногдол ашгийн нөлөө

Дансны нэр

Тайлбар

Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлагнасан ногдол ашгаар:

Дт	Ногдол ашгийн авлага (Холбоотой тал)	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үед зарласан ногдол ашиг*Хөрөнгө оруулагчийн хувь эзэмшил%
Кт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	

Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр ногдол ашиг зарласнаар хөрөнгө оруулалтын дансанд дээрх тохируулгыг хийх боломжтой болдог. Хэрвээ санхүүжигчийн ногдол ашиг зарласан болон олгосон хугацаа адил бол Дт Мөнгөн хөрөнгө дансанд шууд тусгаж болно.

3.3 Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн бусад дэлгэрэнгүй орлогын нөлөө

Дансны нэр

Тайлбар

Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үед тайлагнасан бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрээр:

Дт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрийн
Кт	Нөөц (Бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрээр)	Нөөц (Бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт тус бүрээр)
Дт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	тайлагнасан дүн*Хөрөнгө оруулагчийн хувь эзэмшил%
Кт	Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	

Бусад дэлгэрэнгүй орлогын үзүүлэлт гэдэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү, гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү, болон

ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй бусад олз, гарз гэх мэт орно.

Толгой компани нь хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа дээр дурдсан тохируулгыг хийж, тохируулагдсан дүнгээр нэгтгэсэн санхүүгийн тайландаа тайлагнана.

4 Бизнесийн нэгдлийн үр дүнд бий болсон группын нэгжийг нэгтгэх

Хэрвээ бизнесийн нэгдлийн үр дүнд толгой ба охин компанийн харилцаа тогтсон бол бизнесийн нэгдлийн өдөр болон бизнесийн нэгдлээс хойших тайлант үеүдэд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэнэ.

Ийм хэлбэрээр бий болсон толгой ба охин компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгтгэхдээ худалдан авалтын аргыг ашиглана. Бизнесийн нэгдлийн өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ толгой компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан⁴-ийн үзүүлэлтүүдийг охин компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан⁵-гийн үзүүлэлтүүдтэй мөр мөрийн дагуу нэмэх байдлаар нэгтгэхдээ худалдан авалтын аргыг дараах байдлаар ашиглана:

- а) Нэгтгэгч талыг тодорхойлох:** нэг ба түүнээс дээш аж ахуйн нэгжийг өөртөө нэгтгэсэн буюу хяналтдаа оруулж байгаа аж ахуйн нэгж буюу тухайн бизнесийн нэгдэлд давуу эрхтэй оролцож байгаа тал. Харин тухайн бизнесийн нэгдэлд оролцож байгаа нэгтгэгчээс бусад талыг нэгдэгч гэж үзнэ.
- б) Худалдан авалтын огноог тодорхойлох:** нэгтгэгч тал нь нэгдэгч талд хяналтаа тогтоосон өдөр
- в) Худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөр болон нэгдэгч тал дахь хяналтын эрхгүй хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих:** өөр аж ахуйн нэгжийн хяналтад орсон аж ахуйн нэгжийн буюу нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнийг бизнесийн нэгдлийн өдрөөр үнэлэх ба бизнесийн нэгдэлд нэгдэгч талыг цэвэр хөрөнгийн зах зээлийн үнээр нэгдэхийг шаарддаг. Ийнхүү нэгдэгчийг нэгдлийн өдрөөр цэвэр хөрөнгийн зах зээлийн үнээр нэгтгэсэн гэдгийг илэрхийлэх хэлбэр нь нэгдлийн өдрөөр бэлтгэгдэж байгаа нэгтгэсэн санхүүгийн тайланд устгах бичилтээр нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн болон

⁴ Худалдан авалт байдлаар нэгтгэж байгаа толгой компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь нэгдэгч тал буюу охин компанийг худалдан авахтай холбоотой бүх ажил гүйлгээний нөлөөний дараах байдлаар тусгагдана.

⁵ Худалдан авалт байдлаар нэгтгэгдэж байгаа охин компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь нэгдлийн өмнөх дансны үнээрээ тусгагдана.

дансны үнийн зөрүүг тохируулж өгнө.

Түүнчлэн, бизнесийн нэгдлийн өдрөөр нэгдэгч тал дахь аливаа хяналтын эрхгүй хувь оролцоо эзэмшигчид байгаа бол тэр өдрөөрх хяналтын эрхгүй хувь оролцоо⁶-г эзэмшигчдийн хувь оролцоог тодорхойлж, цэвэр хөрөнгө дэхь хяналтын эрхгүй хувь оролцоо⁷-г нэгдлийн өдрийн Нэгтгэсэн санхүүгийн тайланд устгах бичилтээр хүлээн зөвшөөрнө.

г) **Тохиролцоот худалдан авалтаас үүсэх олз буюу гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих:** бизнесийн нэгдлийн өдрийн толгой компанийн охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дүнгээс охин компанийн тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнээс толгой компанийн эзэмшлийн хувиар үржүүлсэн дүнг хассан зөрүүгээр гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлно. Хэрвээ энэ зөрүү нь эерэг утгатай бол нэгдлийн өдрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Гүүдвил”-ийг биет бус хөрөнгөөр устгах бичилтийн горимоор хүлээн зөвшөөрнө. Харин үүссэн зөрүү нь сөрөг утгатай гарсан бол нэгдлийн өдрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Худалдан авалтын олз”-г тайлант үеийн ашиг алдагдалаар хүлээн зөвшөөрнө. (СТОУС 3 “*Бизнесийн нэгдэл*”-д аливаа холбогдох гүүдвилийг хэрхэн тайлагнахыг тайлбарласан.)

Ийнхүү нэгдлийн өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланд дээрх тохируулгуудыг хийсний дараах байдлаар нэгтгэсэн цэвэр үр дүнг гаргана.

Харин нэгдлээс хойших тайлант үеүдэд худалдан авалт хэлбэрээр бий болсон толгой болон охин компанийн үзүүлэлтүүдийг нэгтгэхдээ нэгтгэх ерөнхий горимыг баримтлахын зэрэгцээ нэгдлийн өдрөөр үнэлсэн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнэ болон дансны үнийн зөрүүг хэрэгжсэн, хэрэгжээгүй дүнгээр тохируулан бүртгэх ба, хэрвээ нэгдлийн өдрөөр эерэг “Гүүдвил”-г нэгтгэсэн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн бол дараагийн тайлант үеүдэд гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзыг нэгтгэсэн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. (СТОУС 3 “*Бизнесийн нэгдэл*”-с илүү дэлгэрэнгүй заавраар хангана)

5 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бусад асуудлууд

Хөрөнгө оруулагчийн санхүүжигчид оруулсан аливаа хөрөнгө оруулалтын төрлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын төрлийн ангилал хооронд гарсан хөдөлгөөн тус бүрт хэрэглэгдэх бүртгэл, тайлагнал, тодруулгын шаардлагуудыг тодорхойлохдоо **Хүснэгт 1**-г ашиглана.

⁶ Хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдийн хувь эзэмшил %=(100%-толгой компанийн хувь эзэмшил %)

⁷ Цэвэр хөрөнгө дэхь хяналтын эрхгүй хувь оролцоо=(Нэгдлийн өдрөөрх нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнэ*хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдийн хувь эзэмшил %)

Гуравдугаар бүлэг. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Толгой компани - Нэг ба түүнээс дээш аж ахуйн нэгжид хяналт тавьдаг аж ахуйн нэгж, Охин компани нь охин компанитай, тэдгээр нь охин компанитай гэх мэтээр үргэлжилсэн холбоо хамааралтай тохиолдолд хамгийн дээд шатны аж ахуйн нэгж, хамгийн дээд шатны аж ахуйн нэгж нь гадаад оронд бүртгэлтэй бол Монгол Улсад бүртгэлтэй охин компаниудын дотроос дээд шатны аж ахуйн нэгж

Охин компани – Толгой компанийн хяналтад байгаа аж ахуйн нэгж

Хараат компани – Тайлагнагч аж ахуйн нэгжийн мэдэгдэхүйц нөлөөтэй аж ахуй нэгж

Хамтарсан үйлдвэр - Хамтарсан үйлдвэр гэдэг нь хэлэлцээрийн цэвэр хөрөнгийг ашиглах эрхтэй тухайн хэлэлцээрт хамтын хяналттай тал бүхий хамтын хэлэлцээр юм. Эдгээр талыг хамтарсан үйлдвэрт оролцогчид гэнэ.⁸

Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж-(а) хөрөнгө оруулалтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор нэг эсвэл хэд хэдэн хөрөнгө оруулагчаас сан бүрдүүлж хүлээн авсан; (б) капиталын үнэ цэнийн өсөлт, хөрөнгө оруулалтын ашгаас өгөөж хүртэх зорилгоор сангаар хөрөнгө оруулалт хийхийг бизнесийн зорилгоо болгохыг хөрөнгө оруулагчдаа даалгадаг; (в) үндсэндээ бүх хөрөнгө оруулалтынхаа гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар хэмжиж үнэлдэг аж ахуйн нэгж

Групп - Толгой компани болон түүний охин компаниуд

Хяналт - Хөрөнгө оруулагч тал санхүүжигч дэх оролцооноосоо хувьсах өгөөж хүртэх эрхтэй эсвэл боломжтой бол, мөн санхүүжигч дэх өөрийн эрх мэдлээрээ дамжуулан тухайн өгөөжид нөлөөлөх чадвартай бол санхүүжигчид хяналттай байна.

Хамтын хяналт - Гэрээний дагуу зөвшөөрсөн хэлэлцээрийн хяналтыг хамтран эзэмших явдал бөгөөд энэ нь зөвхөн холбогдох үйл ажиллагааны талаар гаргах шийдвэрийн дагуу хяналтыг хамтран эзэмшихээр оролцогч талууд санал нэгтэй зөвшөөрсөн тохиролцоо байхыг шаардсан тохиолдолд л оршин байна.

Мэдэгдэхүйц нөлөөлөл - Санхүүжигчийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын талаар шийдвэр гаргахад оролцох эрхтэй тэдгээр бодлогыг дангаараа эсвэл хамтран хянах эрхгүй байхыг хэлнэ.

⁸ Аж ахуйн нэгж нь өөрийн оролцсон хамтын хэлэлцээрийн төрлийг СТОУС 11 “Хамтын хэлэлцээрийн”-ийн дагуу тодорхойлно. Хамтын хэлэлцээр гэдэг нь хоёр эсвэл түүнээс дээш хамтын хяналттай тал бүхий хэлэлцээр. Хамтарсан хэлэлцээрийн ангилал нь тухайн хэлэлцээрт оролцогч талын эрх ба үүргээс хамаарна. Хамтарсан үйлдвэр нь хамтын хэлэлцээрийн нэг төрөл.

Нэгтгэх арга - Толгой компанийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг түүний охин компани тус бүрийн тэдгээр үзүүлэлтүүдтэй мөрийн дагуу нэмэх замаар эдийн засгийн нэг нэгж мэтээр үзэж нэгтгэх арга.

Өмчийн арга - Өмчийн арга гэдгийг хөрөнгө оруулалтыг анхлан зөвшөөрөхөд өртгөөр нь, санхүүжигчийн цэвэр хөрөнгийн хөрөнгө оруулагчийн хувийн өөрчлөлт өмнөх эзэмшлийн дараа залруулга хийх бүртгэлийн аргыг өмчийн арга гэж тодорхойлсон. Хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдалд санхүүжигчийн ашиг, алдагдал багтана. Мөн хөрөнгө оруулагчийн бусад дэлгэрэнгүй орлогод санхүүжигчийн бусад дэлгэрэнгүй орлогын хувь багтана.

Худалдан авалтын арга⁹ - Аж ахуйн нэгж нь бизнесийн нэгдэл тус бүрийг худалдан авалтын аргын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах шаардлагатай. Худалдан авалтын аргыг дараах алхмын дагуу ашиглана. Үүнд:

- (а) Нэгтгэгч талыг тодорхойлох;
- (б) Худалдан авалтын огноог тодорхойлох;
- (в) Худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөр болон нэгдэгч тал дахь хяналтын эрхгүй хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих; болон
- (г) Тохиролцоот худалдан авалтаас үүсэх олз буюу гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан - Толгой компани ба түүний охин компаниудын хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг нэг эдийн засгийн нэгж мэтээр үзэж, хэрвээ толгой компани нь худалдан авах хэлбэрээр охин компанийг өөрийн хяналтдаа оруулсан бол, худалдан авалтын аргын дагуу санхүүгийн тайлангийн холбогдох үзүүлэлтүүдийг тохируулж нэгтгэн толилуулсан группын санхүүгийн тайланд хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар тохируулж Нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан¹⁰ - Аж ахуйн нэгжийн өөрсдийн тодорхой нэг мэдээллийн хэрэгцээнд зориулан тайлан бэлтгэхийг шаарддаггүй, хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад чиглэсэн санхүүгийн тайлан

⁹ Нэгдэгч буюу бизнесийн нэгдлийн үр дүнд өөр аж ахуйн нэгжийн хяналтанд орж байгаа тал нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнээр хэмжигдсэн, хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн охин компани эсвэл нэгдмэл хяналтанд байдаг аж ахуйн нэгж буюу бизнесийн шинж агуулаагүй нэгдлээс бусад бизнесийн нэгдлийг худалдан авалтын аргаар бүртгэлд тусгах ёстойг СТОУС 3 “Бизнесийн нэгдэл”-д заасан.

¹⁰ НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” болон Сангийн сайдын 2012 оны 3-р сарын 28-ний өдрийн 77 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” нь аж ахуйн нэгжийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг хэрхэн бэлтгэх талаар удирдамж болдог.



НЭГТГЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ УДИРДАМЖ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг зүйл

1. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх зорилгоор нэгтгэлд оролцогч талуудыг үнэлэхдээ хяналтын загварыг үндэслэнэ.
2. Хөрөнгө оруулагч нь санхүүжигч аж ахуйн нэгж дэх оролцооныхоо шинж чанараас үл хамааран тухайн санхүүжигчийг хянаж байгаа эсэхээ дараах хяналтын загварт үндэслэн тогтоох замаар **толгой компани** мөн эсэхээ тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хяналтын загварын үндсэн гурван элементийг бүгдийг зэрэг агуулсан хөрөнгө оруулагчийг **толгой компани**, санхүүжигчийг **охин компани** гэж үзнэ.
3. Хяналтын загварын үндсэн гурван элемент:
 - Санхүүжигч дэх эрх мэдэл
 - Санхүүжигч дэх хувь оролцооноосоо хувьсах өгөөж хүртэх эрх эсвэл боломжтой байх
 - Тухайн санхүүжигч дэх эрх мэдлээ ашиглан хөрөнгө оруулагчийн үр өгөөжид нөлөөлөх чадвар

***Жич:** Хөрөнгө оруулагч нь мөн бүхий л баримт нотолгоо, нөхцөл байдлыг тооцож үзсэний үндсэн дээр санхүүжигчид хяналттай байгаа эсэхээ бүхэлд нь үнэлбэл зохино. Хэрэв баримт нотолгоо, нөхцөл байдал нь хяналтын гурван элементийн нэг ба түүнээс дээш элементэд өөрчлөлт орсон болохыг илтгэж байвал хөрөнгө оруулагч тал нь санхүүжигчид хяналттай байгаа эсэхээ дахин авч үзэхийг хөрөнгө оруулагчаас шаардах хэрэгтэй.*

Эрх мэдэл	Өгөөж	Эрх мэдэл болон өгөөжийн хамаарал
<i>Тодорхойлолт:</i>		
Санхүүжигчийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг үйл ажиллагааг удирдан чиглүүлэх	Хувьсах өгөөж хүртэх эрхтэй эсвэл боломжтой байх	Эрх мэдлээ ашиглан санхүүжигчийн өгөөжид нөлөөлөх чадвар

одоогийн чадвар		
Илрэх хэлбэр:		
<ul style="list-style-type: none"> - Саналын эрх - Боломжит саналын эрх - Удирдлагыг томилох эрх - Шийдвэр гаргах эрх - Үйл ажиллагаанаас гаргах эрх <p>Хамгаалалтын эрх биш</p>	<ul style="list-style-type: none"> - Ногдол ашиг - Урамшуулал - Хэмжээнээс хамаарах эдийн засаг, өртөг хэмнэлт - Бусад хувь оролцоог эзэмшигчдэд хуваарилагдахгүй өгөөж 	<ul style="list-style-type: none"> - Шилжүүлсэн эрх - Эрх мэдлийн хамрах хүрээ - Бусад талуудын эзэмшиж буй эрхүүд - Урамшуулал - Бусад ашиг сонирхолд өртөх

4. Ийнхүү үнэлэхийн тулд дараах хүчин зүйлийг авч үзсэнээр санхүүжигч аж ахуйн нэгж дэх хяналтыг үнэлэхэд илүү дөхөм болно. Үүнд:

Асуудал	Тайлбар, хэмжигдэхүүн
Санхүүжигчийн хэв шинж, зорилго	<p>Санхүүжигчийн хэв шинж, зорилгыг үндсэндээ дараах 2 төрөлд ангилж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> > Шийдвэр гаргалтад нөлөөлдөг ямар нэг гэрээ хэлэлцээр, өөр хүчин зүйл байхгүй үед санхүүжигчийн гаргасан хувь тэнцүүлсэн саналын эрхийг эзэмшигчдэдээ өгдөг өмчийн хэрэглүүрээр дамжуулан санхүүжигчийн үйл ажиллагаа, санхүүгийн бодлогыг тодорхойлоход оролцогчдын саналыг үндэслэн хяналтыг нь үнэлнэ. > Шийдвэр гаргалтад ямар нэг гэрээ, хэлэлцээр болон бусад хүчин зүйлс нөлөөлдөг үед санхүүжигчид учирч болзошгүй эрсдэл, санхүүжигчээс оролцогч талуудад шилжих эрсдэл, эдгээр эрсдлээс хөрөнгө оруулагчдын хариуцлага хүлээх эрсдэл нь юу болох зэргийг тооцож үзэх шаардлагатай.
Холбогдох үйл ажиллагаа нь ямар үйл ажиллагаа болох, мөн тэдгээртэй холбоотой шийдвэрийг хэрхэн гаргадаг эсэх	Ихэнх санхүүжигчийн хувьд үндсэн болон санхүүжилтийн үйл ажиллагаа нь тэдний өгөөжид мэдэгдэхүйц нөлөөлөх үйл ажиллагаа байдаг. Санхүүжигчийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөөлдөг үйл ажиллагааг холбогдох үйл ажиллагаа гэж ойлгоно.
Хөрөнгө оруулагчийн эрх нь түүнд холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадамжийг өгч байгаа эсэх	Хөрөнгө оруулагчдад эрх мэдэл өгдөг тусгайлсан эсвэл нийт дундын эрх байж болно. Энэ тусгайлсан болон нийт дундын эрхийг тодорхойлохын тулд тухайн гэрээт хэлэлцээрийг үнэлж дүгнэх шаардлагатай.

Санхүүжигч оролцооноосоо өгөөж хүртэх эрх эсвэл боломж байгаа эсэх	дэх хувьсах үр эсвэл	Хувьсах өгөөж гэдэг нь тогтмол бус, санхүүжигчийн үр дүнгээс хамаараад өөрчлөгдөж болох өгөөж юм. Тэгэхээр уг өгөөж нь эерэг, сөргийн аль аль нь байж болно.
Хөрөнгө оруулагч нь тухайн санхүүжигч дэх эрх мэдлээ ашиглан хөрөнгө оруулагчийн үр өгөөжийн дүнд нөлөөлөх чадвартай эсэх		Шийдвэр гаргагч нь санхүүжигчид хяналттай эсэхээ тогтоохдоо өөрийгөө хэлэлцээрт оролцогч эсвэл агентын аль нь болохоо тодорхойлох нь чухал. Учир нь агент нь шийдвэр гаргах эрх мэдлээ ашиглах үедээ санхүүжигчид хяналтгүй байдаг. Агент нь эрх мэдлээ ашиглан санхүүжигчийн үр өгөөжид нөлөөлөх боломжгүй, харин үндсэн оролцогч тал нь тийм боломжоор хангагддаг.
Санхүүжигчийн талуудтай харилцааны мөн чанарыг нь авч үзэх	бусад байгуулсан	Хяналтыг үнэлэхдээ хөрөнгө оруулагч нь бусад талтай байгуулсан харилцаа холбооны мөн чанар, тэдгээр тал нь уг хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа эсэх (өөрөөр хэлбэл жинхэнэ агент эсэх)-ийг авч үзнэ.

Хоёрдугаар бүлэг. ЭРХ МЭДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

1. Хөрөнгө оруулагч нь санхүүжигчид хяналттай эсэхийг үнэлэхдээ тухайн хөрөнгө оруулагч санхүүжигчид эрх мэдэлтэй эсэхийг тодорхойлно.
2. Хөрөнгө оруулагчийн эрх мэдлийг санхүүжигч дэх аливаа эрхүүдээр тодорхойлдог. Хөрөнгө оруулагч өөрт нь холбогдох үйл ажиллагаа¹¹ - г удирдан чиглүүлэх боломжийг олгодог эрхтэй байвал санхүүжигч талд эрх мэдэлтэй байна. Санхүүжигчийн холбогдох үйл ажиллагааг саналын эрх болон бусад ижил төстэй эрхээр дамжуулан удирдан чиглүүлж байдаг. Дараах үндсэн нөхцөлд хөрөнгө оруулагчийн санхүүжигчид эрх мэдэлтэй эсэхийг тодорхойлно. Үүнд:

2.1 Дийлэнх саналын эрхтэй бөгөөд эрх мэдэлтэй байх

Ихэнх тохиолдолд саналын болон бусад ижил төстэй эрхээр дамжуулаад хөрөнгө оруулагч нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх тухайн үеийн чадамжтай байдаг. Санхүүжигчийн холбогдох үйл ажиллагааг саналын эрхээр удирдан чиглүүлдэг буюу эрх мэдэлтэй гэж тодорхойлохын тулд дараах нөхцөлүүдийн аль нэг хангагдсан байх шаардлагатай. Үүнд:

- › Саналын эрхийн дийлэнхийг эзэмшигчийн саналаар холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг байх
- › Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг удирдах байгууллагын гишүүдийн

¹¹ Санхүүжигчийн үр өгөөжид мэдэгдэхүйц нөлөөлдөг үйл ажиллагаа

олонхийг саналын эрхийн дийлэнх хувийг эзэмшигчийн саналаар томилдог байх.

2.2 Дийлэнх саналын эрхтэй боловч эрх мэдэлгүй байх

Дээрх 1-д дурдсан нөхцөл биелээгүй байх үеийн санхүүжигчийн саналын эрхийн хагасаас илүүт эзэмшиж буй хөрөнгө оруулагчийн санхүүжигч дэх эрх мэдэлтэй эсэхийг тогтоохын тулд тухайн хөрөнгө оруулагчийн саналын эрх нь бодитой байх шаардлагатай гэж үздэг. Бодитой эрх нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх тухайн үеийн эрхийг хөрөнгө оруулагчид өгөх ёстой бөгөөд тухайн үеийн энэ эрх нь гол төлөв үйл ажиллагааны болоод санхүүжилтийн бодлогыг тодорхойлох явдал байдаг.

Энэ үед хөрөнгө оруулагч нь санхүүжигчид эрх мэдэлтэй эсэхээ тогтоохын тулд зөвхөн санхүүжигчтэй холбоотой **бодитой эрх**¹² -үүдийг л авч үзнэ. Эрх нь бодитой эсэхийг тодорхойлоход бүхий л баримт болон нөхцөл байдлыг харгалзсан шийдэл шаардагдах бөгөөд хамгийн наад зах нь дараах зүйлүүдийг шалгасны үндсэн дээр бодит эсэхийг нь тодорхойлно. Үүнд:

- › Эзэмшигч нь тухайн эрхээ ашиглахад саад болж буй ямар нэг хаалт (эдийн засгийн болон бусад) байгаа эсэхийг үнэлэх
- › Эрхээ хэрэгжүүлэхэд нэгээс дээш талын гэрээ шаардлагатай болдог, эсвэл энэхүү эрхийг нэгээс дээш тал эзэмшиж байгаа тохиолдолд талууд хамтран эрхээ эдлэх сонголтыг хийсэн бол эрхээ хамтран эдлэх бодит чадамжийг тэдэнд өгдөг тогтолцоо байгаа эсэх.
- › Тухайн эрхийг эзэмшиж буй нэг эсвэл хэд хэдэн тал тэдгээр эрхээ эдэлснээр өгөөж хүртэх эсэх.

Дээрх нөхцөлүүдийн гол санаа нь бодитой байхын тулд эрх нь холбогдох үйл ажиллагааны чиглэлийн талаарх шийдвэр гаргах үед хэрэгжихүйц байх шаардлагатай. Тухайн эрх нь бодит биш л бол санхүүжигчийн саналын эрхийн дийлэнхийг хөрөнгө оруулагч эзэмшдэг байсан ч уг хөрөнгө оруулагч нь санхүүжигчид эрх мэдэлгүй байна.

Нэмэлт тайлбар: Хэрэв холбогдох үйл ажиллагааны эрхийг өөрт нь өгдөг өөр аж ахуйн нэгж байгаа бөгөөд тухайн аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулагчийн агент биш бол хөрөнгө оруулагч нь санхүүжигчид эрх мэдэлгүй байна.

2.3 Дийлэнх саналын эрхгүй боловч эрх мэдэлтэй байх

Хөрөнгө оруулагч санхүүжигчийн саналын эрхийн талаас бага хувийг эзэмшдэг боловч санхүүжигчийн өгөөжийн талаас илүү хувийг авах эрхтэй эсвэл боломжтой тохиолдол байж болно.

¹² Хөрөнгө оруулагч ба бусад талуудын эзэмшиж буй эрх нь бодит буюу үндэслэлтэй байхын тулд эзэмшигч нь түүнийг хэрэгжүүлэх практик чадамжтай байх ёстой.

Энэ үед хөрөнгө оруулагч нь саналын эрхтэй адилтгах дараах бусад эрхүүдээр дамжуулан эрх мэдэлтэй эсэхээ тодорхойлно. Үүний тулд хамгийн багадаа дараах зүйлсийг үнэлэх нь зүйтэй. Үүнд:

- Тухайн хөрөнгө оруулагч болон бусад саналын эрх эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээт хэлэлцээрээс үүсэх эрх¹³
- Бусад гэрээт хэлэлцээрээс үүсэх эрх¹⁴
- Тухайн хөрөнгө оруулагчийн саналын эрх¹⁵
- Боломжит саналын эрх¹⁶
- (1)-ээс (4)-ийн хослол¹⁷

Дээрх дурдсан эдгээр эрхүүд нь дангаараа болон хамтраад эрх мэдэл үүсгэж байгаа эсэхийг тодорхойлно.

Саналын эрх болон бусад ижил төстэй эрхүүд санхүүжигчийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөөгүй байх үеийн эрх мэдэл

Санхүүжигчийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохдоо санхүүжигчийг үүсгэн байгуулах үед түүний зорилгын хүрээнд гаргасан шийдвэр болон оролцоог авч үзэх ба уг оролцооны онцлог, ажил гүйлгээний нөхцөл нь хөрөнгө оруулагчид эрх мэдэлтэй байхад хангалттай эрхийг өгч байгаа эсэхийг үнэлнэ.

3. Дээрх 4 тохиолдлыг шат дараалан үнэлэх байдлаар эрх мэдэлтэй эсэхээ тодорхойлно.

Гуравдугаар бүлэг. ӨГӨӨЖИЙГ ҮНЭЛЭХ НЬ

1. Хөрөнгө оруулагч нь санхүүжигчид хяналттай эсэхийг үнэлэх үедээ тухайн хөрөнгө оруулагч санхүүжигч дэх оролцооноосоо хувьсах өгөөж хүртэх боломжтой эсвэл эрхтэй эсэхийг тодорхойлно.
2. Хувьсах өгөөж гэдэг нь тогтмол бус, санхүүжигчийн үр дүнгээс хамаараад өөрчлөгдөж болох өгөөж юм. Үүнд: санхүүжигчийн тухайн тайлант жилийн орлого үр дүн, өмчийн хуваарилалт зэргийг ойлгоно.

